



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 0/75

Ховд

**Норовын Даваажаргалд буцалтгүй  
тусламж үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.4, 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Цахим засаглалын асуудал, төрийн үйлчилгээний нэгдсэн портал хариуцсан мэргэжилтэн Норовын Даваажаргалын гэр бүлд шинэ хүүхэд мэндэлсэн тул 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлж 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Н.Даваажаргалд 100,000 төгрөг (нэг зуун мянга)-ийн буцалтгүй тусламж олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.



84.00 03 0792  
Tush B/75 Ba